

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2023/95/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2021 он	Дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn "Анализ старт аудит" ХХК-ийн Ахлах аудитор А.Батжаргал Утас: 99291595 Цахим хаяг: asaudit.mn@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЦЭЭЛ СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
А.СЭВЖИДМАА ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2025.02.25 № 94

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Говь-Алтай аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар ажиллагсдад амралт, цалин давхардуулан олгосон, санхүүгийн тайланд өглөг үүсгэлгүй илүү цагийг өглөг үүсгэлгүй олгосон, зардлын эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн, үнэ төлбөргүй нийлүүлсэн хөрөнгийн орлого аваагүй, Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй зэрэг 16.8 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, АДБОУС 1250, иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр баталсан. Энэ хуулиар байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь тайлант онд 7 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 90.6 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

07020155

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган. төгрөг/

	Үзүүлэлт	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
	Эргэлтийн хөрөнгийн дүн	327,718.5
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	940,819.5
	Нийт хөрөнгийн дүн	1,268,537.9
	Нийт өр төлбөрийн дүн	0.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,268,537.9
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,268,537.9
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,790,398.1
	Үйл ажиллагааны зардлын дүн	739,509.7
	Үйл ажиллагааны үр дүн	1,050,888.4
	Үйл ажиллагааны бус үр дүн	0.00
	Үйл ажиллагааны нийт үр дүн	1,050,888.4
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	217,649.5
	Тайлант оны үр дүн	1,050,888.4
	Эцсийн үлдэгдэл	1,268,537.9
Мөнгөн гүйлгээний тайлан		
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	848,337.9
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	601,696.1
	Үйл ажиллагааны ЦМГ	246,641.8
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	30,713.1
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0.0
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	215,928.7
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	215,928.7
Төсвийн гүйцэтгэлийн тайлан УТ		
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	609,909.2
	Урсгал зардал	609,909.2
	Хөрөнгийн зардал	
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	816,152.8
	Эрүүл мэндийн даатгалын сангаас	597,407.8
	Туслах үйл ажиллагааны орлогоос	218,745.0
	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	215,928.7
Төсвийн гүйцэтгэлийн тайлан ОН		
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	22,484.1
	Урсгал зардал	22,484.1
	Хөрөнгийн зардал	
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	22,484.1
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	22,484.1

Гурав. Аудитын илрүүлэлт:

зарцуулсан нь "Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах"; Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Эдийн засгийн ангилал ашиглах заавар " заалтыг зөрчсөн , нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- ✓ Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд 2.1 сая төгрөгийг дутуу шивсэн нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" заалтыг зөрчсөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Тендерт шалгараагүй аж ахуйн нэгж байгууллагаас 9.3 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авсан нь "Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно " заалтыг зөрчсөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Тендерт шалгараагүй иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас 2.3 сая төгрөгийн эм боох материал худалдаж авсан нь Төсвийн тухай хуулийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Төрийн хэмнэлтийн хуулийг зөрчиж түлшний зардлыг 0.7 сая төгрөгөөр, цэвэр бохир усны зардлын төсвийн 0.2 сая төгрөгөөр тус тус төсвөөс хэтрүүлэн зарцуулсан нь "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т "байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх" заалтыг зөрчсөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй нийлүүлсэн 3.8 сая төгрөгийн эмийг орлого аваагүй нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;/, 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;", 20.2.6-т /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;/, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын

Аудитаар нийт 9.5 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитаар залруулсан. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой: Мөнгөн гүйлгээний тайланд харилцах данс хоорондын гүйлгээг орлого, зарлага хийгдсэн байдлаар илэрхийлсэн 9.5 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн алдаа гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 41.5 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 0.3 сая төгрөгийн 1 заалт төлбөрийн акт тогтоож, 41.2 сая төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх 7 заалт албан шаардлага, хуулийн хэрэгжилт хангах 2 заалт зөвлөмж хүргүүлсэн.

3.1 Төлбөрийн акт

- ✓ Амралтын цалинг үндсэн цалинтай давхардуулан 0.3 сая төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Албан шаардлага

- ✓ Ажилчдын 2021 оны 11, 12 дугаар сарын 6.7 сая төгрөгийн илүү цагийн хөлсийг өглөгөөр тайлагнаагүй байтал 2022 оны 02 дугаар сард нөхөн олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3 дугаар бүлгийн 2-т "Нэмэгдэл хөлсийг төрийн албан хаагчийн илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны дараа сарын цалин хөлстэй хамт тооцож олгоно" заалтыг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Улсын төсвийн санхүүжилтээс 4.2 сая төгрөгийн нүүрсний үнийг, 0.1 сая төгрөгийн гэрэл цахилгааны үнийг, 0.8 сая төгрөгийн шатахууны үнийг зардлын зүйл анги зөрчиж бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж зардлаас

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэж заасныг зөрчсөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- ✓ Төсвийн хэмнэлтийн тухай хуулийн үр ашигтай байх зарчмыг баримтлаагүй 13.3 сая төгрөгийн түлшний хөнгөлөлтийн зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т "Энэ хуулийн 4.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 4.2.3.хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх; 4.2.6.үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх;" гэж заасныг зөрчсөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын бүртгэлд байгаа авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглээгүй байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ", заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авто тээврийн хэрэгсэлд тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэх

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны мэдээллийг түүвэрчилж үзэхэд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1 төрлийн 8.0 сая төгрөгийн зарлагын гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.4. таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; 6.4.5. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/												
Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулааг үй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Говь-Алтай аймгийн Цээл сумын ЭМТ	1	9.6			1	9.6	1	9.6	-	-		-
Дүн	1	9.6			1	9.6	1	9.6	-	-		-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	/сая төгрөгөөр/ Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Говь-Алтай аймгийн Цээл сумын ЭМТ	5	16.8	1	0.3	4	16.4						
Дүн	5	16.8	1	0.3	4	16.4	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	/сая төгрөгөөр/ Үүнээс							
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Говь-Алтай аймгийн Цээл сумын ЭМТ	5	24.7	-	-	3	24.7	2	
Нийт дүн	5	24.7	-	-	3	24.7	2	

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	-	1	-	-
	НИЙТ	1	1	-	-	-	1	-	-